

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах, нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаа нь аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байх зарчмыг баримтлана.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль дараах харилцаанд үйлчилнэ:

4.1.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

4.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа буюу тус улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол, гадаад улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа, эсхүл тухайн улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа Монгол Улсын иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа.

4.2. Энэ хууль нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн **байлдааны үүргийн** нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг зохицуулна.

Энэ хууль нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн хувьд зөвхөн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулна.

4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт онц болон дайны байдал зарласан үед иргэний нисэхийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “агаараас гүйцэтгэх ажил” гэж агаарын хөлгөөр гүйцэтгэх хөдөө аж ахуй, барилга, зураг авах, судалгаа, ажиглалт ба эргүүл хийх, эрэн хайх ба авран туслах, зар сурталчилгаа болон нислэгээр гүйцэтгэх бусад ажил үйлчилгээг;

5.1.2. “агаарын зай” гэж агаарын хөлөг аюулгүй хөөрөх, буух бүсийг багтаасан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх нислэг үйлдэх боломжтой агаарын орон зайг;

- 5.1.3. “агаарын зам” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэхэд зориулагдсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;
- 5.1.4. “агаарын навигацийн байгууламж” гэж агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөн болон буулт, хөөрөлтийг удирдан чиглүүлэхэд зориулагдсан гэрэлтүүлэг, радио навигаци, цаг агаарын мэдээ дамжуулах, радио холбооны болон ажиглалтын төхөөрөмж, барилга, бусад байгууламжийг;
- 5.1.5. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний менежмент, холбоо, навигаци, ажиглалтын, нисэхийн мэдээллийн, нисэхийн цаг уурын мэдээллээр хангах болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах үйлчилгээг;
- 5.1.6. “агаарын тээвэрлэгч” гэж агаараар зорчигч, ачаа, тээшийг төлбөртэй тээвэрлэдэг агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.7. “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж хуулийн этгээд нь агаарын тээврийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх чадамжтай болохыг нотолж, эрх олгосон баримт бичгийг;
- 5.1.8. “агаарын хөлөг” гэж газрын гадаргуутай харилцан үйлчилснээс бусад, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд өөрөө тогтох чадвартай төхөөрөмжийг;
- 5.1.9. “агаарын хөлгийн дарга” гэж тухайн агаарын хөлгийн багийг ахлаж, жолоодлого болон аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон нисгэгчийг;
- 5.1.10. “агаарын хөлгийн осол, инцидент гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-т тодорхойлсныг;
- 5.1.11. “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба” гэж агаарын хөлгийн осол, инцидентийг Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах эрх бүхий байгууллагыг;
- 5.1.12. “аэродром” гэж агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулан газар, эсхүл усан дээр байгуулсан талбай болон байгууламжийг;
- 5.1.13. “аэродром орчмын аюулгүйн бүс” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон аэродром орчмын газар, эсхүл усан гадаргуу, агаарын орон зайг;
- 5.1.14. “Аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа, төрөл бүрийн эх үүсвэрээс үндэслэн агаарын хөлгийн осол, инцидентээс сэргийлэх зорилгоор Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанаас гаргасан баримт бичгийг;
- 5.1.15. “аюултай бараа” гэж агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин болон нислэгийн аюулгүй байдалд хохирол учруулж болох, техникийн зааварчилгаанд заасан биет зүйл болон бодисыг;
- 5.1.16. “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг, түүнд байгаа хүнд аюултай байж болзошгүй, эсхүл яаралтай тусламж шаардлагатай нөхцөл байдалд орсон агаарын хөлгийг;
- 5.1.17. “багийн гишүүн” гэж нислэгийн үед агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг;
- 5.1.18. “бүртгэгч улс” гэж агаарын хөлгийг бүртгэсэн улсыг;
- 5.1.19. “зорчигч” гэж арилжааны нислэгийн хувьд тээвэрлэлтийн гэрээний дагуу агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг; арилжааны бус нислэгийн хувьд агаарын хөлөгт зорчиж байгаа, багийн гишүүдээс бусад этгээдийг;
- 5.1.20. “нислэгийн оператор” гэж агаарын тээвэрлэгчээс бусад, нислэгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.21. “иргэний нисэхийн дүрэм” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Чикагогийн конвенцийн Хавсралтуудыг үндэслэн баталсан иргэний нисэхийн дүрмийг;
- 5.1.22. “нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч” гэж иргэний нисэхийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх зорилгоор Даргын томилсон, зохих ёсоор бэлтгэгдсэн ажилтныг;
- 5.1.23. “нислэг” гэж нислэгийн үйл ажиллагааны хувьд агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор хөдлөхөөс эхлэн газардах, хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл ажиллагаа; эсхүл агаарын тээвэрлэгчийн хариуцлагын хүрээг тодорхойлох

- зорилгын хувьд тээвэрлэлтийн гэрээ байгуулсан зорчигч агаарын хөлөгт сууснаас эхлэн агаарын хөлгөөс буух хүртэлх хугацаанд хамаарах үйл явдал;
- 5.1.24. “нислэгийн ажилтан” гэж нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй дараах ажилтныг:
1/ нисэх багийн гишүүн, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан, нислэгийн хөдөлгөөний удирдагч;
2/ нислэгийн диспатчер, нислэгийн мэдээллийн ажилтан, бүхээгийн ажилтан, холбоо навигацгийн техникийн ажилтан.
- 5.1.25. “аюулгүй байдал” гэж иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж байгаа эрсдлүүдийг хүлээн зөвшөөрч болох түвшинд хүртэл бууруулж, хяналтад байлгах нөхцөл байдлыг;
- 5.1.26. “аюулгүйн хамгаалалт” гэж иргэний нисэхийг хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахыг;
- 5.1.27. “нисэх буудал” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборыг;
- 5.1.28. “нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс, түүний бүрдэл хэсэг нь маягийн гэрчилгээ болон нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа нөхцөл байдлыг;
- 5.1.29. “олон улсын нислэг” гэж хоёр, түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;
- 5.1.30. “орох, гарах цэг” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байршилыг;
- 5.1.31. “улсын агаарын хөлөг” гэж цэрэг, цагдаа, гаалийн зориулалтаар ашиглаж байгаа агаарын хөлгийг;
- 5.1.32. “Чикагогийн конвенци” гэж Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо батлагдсан олон улсын конвенци болон түүний Хавсралтуудыг;
- 5.1.33. “Шинжлэн шалгах багийн ахлагч” гэж шинжлэн шалгах ажиллагааг удирдах, хянах, гүйцэтгэхээр томилогдсон мэргэшсэн шинжлэн шалгагчийг;
- 5.1.34. “шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийн ослоос сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх болон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоосон дүгнэлт, шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

- 6.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.1.1. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;
- 6.1.2. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 6.1.3. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг батлах;
- 6.1.4. иргэний нисэхийн үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг батлах;
- 6.1.5. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор, Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргыг томилох;
- 6.1.6. орон нутгийн агаарын тээврийн нийгмийн зайлшгүй үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай татаас олгох асуудлыг шийдвэрлэх;
- 6.1.7. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн олон улсын нисэх буудал байгуулах асуудлыг шийдвэрлэх;
- 6.1.8. хуульд заасан бусад.

7 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь иргэний нисэхийн салбарын үйл ажиллагааг Засгийн газрын бодлогын хүрээнд хянаж, удирдан чиглүүлэх үүрэг хүлээж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- 7.1.2. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын хэрэгжилтийг хангуулах;
- 7.1.3. Чикагогийн конвенцийн 1 дүгээр зүйлд заасан онц бүрэн эрхийг Монгол Улсын агаарын зайд хэрэгжүүлэх;
- 7.1.4. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг байгуулах;
- 7.1.5. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах;
- 7.1.6. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны Ерөнхий шинжлэн-шалгагчийг, томилох;
- 7.1.7. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны дүрмийг батлах;
- 7.1.8. агаарын хөлгийн осол, инцидентыг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;
- 7.1.9. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба бие даан гүйцэтгэхэд техник, технологи, хүн хүчний боломж дутагдалтай гэж үзвэл Хэлэлцэн тохирогч улсын шинжлэн шалгах байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл түүнд хэсэгчлэн, эсхүл бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- 7.1.10. энэ хуулийн 8.3-т заасан санхүүжилтийн төсвийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;
- 7.1.11. иргэний нисэхийн дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 7.1.12. агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 7.1.13. олон улсын нислэгийн шугам хуваарилах, тухайн шугаманд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;
- 7.1.14. агаарын хөлгийн түрээсийн асуудал;
- 7.1.15. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зайн ангилал, орох, гарах цэг, агаарын замыг тогтоох;
- 7.1.16. агаарын тээврийн зохицуулалт, агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг энэ хуулийн 8.4-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх;
- 7.1.17. Иргэний нисэхийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж олгох нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлах;
- 7.1.18. хуульд заасан бусад бүрэн эрх.

7.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ **хуулийн 8 дугаар зүйл 8.1, -т заасан заасан байгууллагын төсвийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлана.**

7.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 7.1.3-т заасан онц бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ нислэгийн аюулгүй байдлын хяналт зохицуулалт хэрэгжүүлэх эрхийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдах эрхийг агаарын навигацыйн үйлчилгээний байгууллагад тус тус шилжүүлэн гүйцэтгүүлнэ.

7.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрхлэх нийтлэг асуудал, түүний санхүүжилт

8.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

8.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.2.1. нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын чиглэлээр:

8.2.1.2. агаарын хөлгийн бүртгэл;

8.2.1.3. агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хяналт, гэрчилгээжүүлэлт;

8.2.1.4. нислэгийн үйл ажиллагааны хяналт, гэрчилгээжүүлэлт;

8.2.1.5. нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт.

8.2.2. иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтын чиглэлээр:

8.2.2.1. агаарын навигацийн үйлчилгээний хяналт, гэрчилгээжүүлэлт;

8.2.2.2. аэродромын хяналт, гэрчилгээжүүлэлт;

8.2.2.3. нисэхийн аюулгүйн хамгаалалтын хяналт, гэрчилгээжүүлэлт.

8.2.3. Иргэний нисэхийн дүрэм болон бусад эрх зүйн акт боловсруулах;

8.2.4. иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын асуудлаар олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ажиллах;

8.2.5. үнэмлэх, гэрчилгээ олгохтой холбоотой шалгалт авах, үзлэг хийх ажлын үнэлгээг тэдгээрийг гүйцэтгэхэд зарцуулах өртөгт суурилан тогтоох;

8.2.6. аэродром байгуулах, аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтоох асуудлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх;

8.2.7. өмчийн хэлбэрээс үл хамаарч нийтийн хэрэглээний нисэх буудал, аэродромын төлөвлөлт, ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх;

8.2.8. иргэний нисэхийн салбарт холбогдох мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар бусад этгээдтэй хамтран ажиллах;

8.2.9. хуульд заасан бусад.

8.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 8.2-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилттэй байна.

8.4. Энэ хуулийн 7.1.16 болон 8.3-т заасан санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

8.4.1. үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагааны хураамж;

8.4.2. иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтын ногдол - Монгол Улсын нутаг дэвсгэрт буулгүйгээр дамжин өнгөрөх нислэгт үзүүлсэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хоёр хувь;

8.4.3. нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын ногдол - Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэгт нийлүүлэгдэж байгаа тийрэлтэт хөдөлгүүрийн түлшний үнийн дүнгийн хоёр хувь;

8.4.4. нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын ногдол – олон улсын нисэх буудлын зорчигчийн хураамжийн дөрвөн хувь;

8.4.5. төрийн болон бусад санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр;

8.4.6. өөрийн үзүүлсэн зөвлөх болон нислэгийн аюулгүй байдлын сургалтын үйлчилгээний орлого;

8.4.7. байгууллагын оюуны өмчийн эрхэд хамаарах бусад орлого.

8.5. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч, ажилтны дундаж цалингийн хэмжээ салбарын адилтгах мэргэжлийн ажилтны цалингийн дунджаас тав болон түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

8.6. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нисэхийн аюулгүйн хяналтын байцаагчийг энэ хуулиар олгогдсон хяналтын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хувцас, хэрэгслээр хангана.

9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад тавих шаардлага

9.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь дараах шаардлагыг хангасан байна:

9.1.1. Энэ хуулийн 5.1.24-ийн 1-д заасан нислэгийн ажилтнаар, эсхүл нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч, итгэмжлэгдсэн шалгагчаар ажилласан ажлын дадлага туршлагатай;

9.1.2. олон улсын иргэний нисэхийн байгууллагын албан ёсны хэрэглээнд ашигладаг гадаад хэлний мэдлэгтэй;

9.1.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгодог гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдээс санхүүгийн хамааралгүй.

9.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь нислэгийн аюулгүйн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

10 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх

10.1. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. иргэний нисэхийн дүрмийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зөвлөмжийн цуврал, маягт, зохион байгуулалт, технологийн бусад баримт бичгийг батлах;

10.1.2. иргэний нисэхийн дүрэмд заасан үнэмлэх, гэрчилгээ олгох;

10.1.3. Хэлэлцэн тохирогч бусад улстай нислэгийн аюулгүй байдлын хяналтын үүрэг, хариуцлага хуваалцах гэрээ байгуулах;

10.1.4. аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн осол, инцидентээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

10.1.5. онцгой нөхцөл үүссэн үед нислэгийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор нэн даруй хэрэгжүүлэх шийдвэр гаргаж нийтэд яаралтай мэдээлэх, хэрэгжилтийг хянах;

10.1.6. энэ хуулийн 8.3-т заасан санхүүжилтийг иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа болон ажилтнуудын сургалт, нийгмийн баталгааг хангахад зориулан захиран зарцуулах;

10.1.7. агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, техник үйлчилгээний байгууллага, сургалтын байгууллага, нислэгийн ажилтан, агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс болон түүний бүрдэл хэсэгт үзлэг шалгалт хийх;

10.1.8. аэродром, агаарын навигацийн үйлчилгээний байгууллага, түүний ажилтан, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх;

10.1.9. агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвараа алдсан, эсхүл тухайн нислэг нь зорчигчид болон бусдын амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй бол нислэгийг зогсоох;

10.1.10. иргэний нисэхийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.1.11. хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч болон бусад этгээдэд эрх шилжүүлэх

11.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.1.9, 10.1.10-т заасан эрхээ нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч, итгэмжлэгдсэн шалгагчид гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болох бөгөөд тухайн шилжүүлсэн эрхийн хязгаарлалт, хугацааг гэрээнд тодорхой заана.

11.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хуулийн 11.1-д заасан эрхийг хэрэгжүүлэхдээ агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхээ шилжүүлэхгүй.

11.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга зохих ёсоор мэргэшсэн иргэнд эрх шилжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг хангасан байна.

11.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтан, шүхэрчин, шүхрийн техникчийн гэрчилгээ олгох эрхийг нисэх клубт шилжүүлж болно.

11.5. Энэ хуулийн 10.1.9, 10.1.10-т заасан эрхийг шилжүүлж авсан этгээд гаргасан шийдвэрийн үндэслэлийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргад нэн даруй тайлагнана.

11.6. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хуулийн 11.1-д заасны дагуу эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

12 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч, түүний бүрэн эрх

12.1. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагчаар томилогдох этгээд нь түүний шалгах, хянах этгээдтэй ижил болон түүнээс дээш түвшиний мэргэшил, ур чадварын шалгуурыг хангасан, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчилгүй байна.

12.2. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.3.1. Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт үзлэг шалгалт хийх зорилгоор аль ч үед саадгүй нэвтрэх;

12.3.2. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламж, объектод аль ч үед саадгүй нэвтрэх;

12.3.3. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах;

12.3.4. Даргын шилжүүлсэн бусад эрх.

12.4. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь түүний эрхийн хүрээг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

12.5. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч энэ хууль, иргэний нисэхийн дүрэм, ерөнхий байцаагчийн баталсан хяналтын зааврын хүрээнд хяналтын үйл ажиллагаа явуулна.

12.6. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагчийн дүгнэлтэд аливаа албан тушаалтан хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

12.7. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нислэгийн аюулгүй байдлын талаар өөрийн гаргасан шийдвэрийн үнэн зөвийг хариуцна.

12.8. Нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь хяналт шалгалтын явцад олсон мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРМИЙН ЗОХИЦУУЛАЛТ

13 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрэм

13.1. Иргэний нисэхийн үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн зохицуулахдаа иргэний нисэхийн дүрмийг баримтална.

13.2. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалтад иргэний нисэхийн дүрэм, түүний тайлбарыг агуулсан зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтэр багтана.

14 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа

14.1. Иргэний нисэхийн дүрмээр иргэний нисэхийн үйл ажиллагааны ерөнхий журам, агаарын хөлөг, ажилтнууд, агаарын зай, нислэгийн үйл ажиллагаа, агаарын тээвэрлэгч, гэрчилгээжсэн байгууллага, аэродром болон агаарын навигацийн байгууллагын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

14.2. Иргэний нисэхийн дүрмээр нислэгийн аюулгүй байдалтай холбоотой дараах харилцааг зохицуулна:

- 14.2.1. иргэний нисэхийн дүрэмд хэрэглэх нэр томъёоны тодорхойлолт, товчлол;
- 14.2.2. инцидентийг мэдээлэх;
- 14.2.3. албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 14.2.4. агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон нэмэлт шаардлага, техник үйлчилгээ;
- 14.2.5. аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шилжилтийн зохицуулалт;
- 14.2.6. нислэгийн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ;
- 14.2.7. агаарын зайг тогтоох, ангилах болон нислэг үйлдэх агаарын зайн зохицуулалт;
- 14.2.8. нислэгийн хөдөлгөөн, нисэхийн холбоо, навигаци, ажиглалт, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.9. нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, хэрэглэлийн нислэгийн журам;
- 14.2.10. жиро-глайдер, парасэйл болон хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 14.2.11. хэт хөнгөн, глайдер, ханг-глайдер болон шүхрийн үйл ажиллагаа, нисэх клубийн гэрчилгээжүүлэлт;
- 14.2.12. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт, жижиг, дунд, том агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 14.2.13. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт болон агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр;
- 14.2.14. нисдэг тэрэгний дүүжинт тээврийн, хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа, чөлөөт нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;
- 14.2.15. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.16. нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.17. агаараар аюултай бараа тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.18. аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт;
- 14.2.19. нислэгийн хөдөлгөөн, нисэхийн холбоо, навигаци, ажиглалт, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.20. үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагааны хураамж.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан үйл ажиллагааг иргэний нисэхийн нэг, эсхүл хэд хэдэн дүрмээр зохицуулж болно.

14.4. Иргэний нисэхийн дүрэм нь олон улсын ижил төстэй иргэний нисэхийн баримт бичигтэй уялдаатай хөгжих бололцоотой бүтэц, дугаарлалттай байна.

15 дугаар зүйл. Дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх

15.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга иргэний нисэхийн дүрмээр хориглоогүй, дүрмийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хангасан бөгөөд нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, аэродром, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч болон нислэгийн ажилтныг иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг өөр байдлаар хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно.

15.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх тухай шийдвэрийг бичгээр гаргаж, нийтэд нэн даруй мэдээлнэ.

15.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга өөрийн хамаарал бүхий этгээдийг иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх шийдвэр гаргахыг хориглоно.

15.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ зүйлийн 15.1-д заасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

16 дугаар зүйл. Нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх шийдвэр гаргах албан тушаалтныг томилох

16.1. Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээждэг байгууллагыг удирдах албан тушаалтан тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой чиглэлээр иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байна.

16.2. Энэ зүйлийн 16.1-д заасан удирдах албан тушаалтнаар томилогдох этгээд нь иргэний нисэхийн дүрэмд заасан тохирох, зөв хүний шаардлагыг хангасан байна.

16.3. Энэ зүйлийн 16.1-д заасан шалгалтыг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн явуулна.

17 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх

17.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглах техник, технологийн баримт бичгийг англи, орос хэл дээр хэрэглэж болно.

17.2. Агаарын хөлөг, нислэгийн хөдөлгөөний удирдагч хоорондын газар-агаар радио холбоонд англи, монгол хэл ашиглах ба онцгой тохиолдолд харилцан бүрэн ойлголцох өөр хэл ашиглаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

18 дугаар зүйл. Агаарын хөлгийн бүртгэл

18.1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

18.2. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг Монгол Улсын агаарын хөлөг гэж тооцно.

18.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь агаарын хөлгийн үндэсний харьяаллыг тодорхойлох бүртгэлийн тогтолцоотой байна.

18.4. Монгол Улсад, эсхүл гадаад улсад бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэхийг хориглоно.

18.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх бөгөөд агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

19 дүгээр зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

19.1. Арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн маягийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Монгол Улсад ашиглана.

19.2. Агаарын хөлгийн үйлдвэрлэгч улсын нислэгт тэнцэх чадварын стандартыг Монгол Улсад хүлээн зөвшөөрвөл, уг стандартын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлгийн маягийг шууд хүлээн зөвшөөрнө.

19.3. Агаарын хөлгийн нэмэлт маягийн гэрчилгээг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргын зөвшөөрөлтэй хэрэглэнэ.

19.4. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ эзэмших хүсэлтийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргад гаргана.

19.5. Агаарын хөлгийн маягийн гэрчилгээний болон аюулгүй байдлын нөхцөл, шаардлагад нийцэж байгаа нь үзлэг шалгалтаар тогтоогдсон агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

19.6. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн ашиглалтын хэлбэр болон аюулгүй байдлыг хангахад шаардагдах ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг тусгана.

19.7. Агаарын хөлөгт гарал үүсэл, эзэмшлийн түүх нь тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн нөхцөлд нийцээгүй хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл болон бусад эд ангийг байрлуулан ашиглахыг хориглоно. Туршилтын бус нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлөгт байрлуулах эд ангийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн байна.

19.8. Хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг, агаарын хөлгийн загвар болон алсын удирдлагатай нисэх төхөөрөмжөөс бусад агаарын хөлөг хүчин төгөлдөр нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй нислэг үйлдэхийг хориглоно.

20 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгч болон нислэгийн операторын гэрчилгээ

20.1. Агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын иргэн нь иргэний нисэхийн дүрмээр тогтоосон шаардлагын хүрээнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл нислэгийн операторын гэрчилгээ эзэмших хүсэлтийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргад гаргана.

20.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл нислэгийн операторын гэрчилгээ олгоно.

20.3. Агаарын тээвэрлэгчийн болон нислэгийн операторын гэрчилгээ нь эрх бүхий этгээд хүчингүй болгох, цуцлах хүртэл хүчинтэй байна.

20.4. Энэ зүйлийн 20.2-д заасны дагуу олгосон гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

21 дүгээр зүйл. Ажилтны үнэмлэх, гэрчилгээ

21.1. Нислэгийн ажилтанд тавигдах шаардлагыг иргэний нисэхийн дүрмээр тогтооно.

21.2. Агаарын тээврийн болон арилжааны нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхгүй нисгэгчийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

21.3. Гадаад улсын иргэний нисэхийн байгууллагаас олгосон үнэмлэх эзэмшигч нь Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаанд оролцох бол Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагын Дарга тухайн үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх, хориглох, эсхүл тодорхой хязгаарлалт тавьж болно.

22 дугаар зүйл. Сургалт

22.1. Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн маягийн агаарын хөлгийн үйлдвэрлэгч улсад тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьдаг мэргэжлийн сургалтын зохих шаардлагыг хангасан нислэгийн ажилтны мэргэшлийг Монгол Улсад хүлээн зөвшөөрнө.

22.2. Нислэгийн хөдөлгөөний удирдагч бэлтгэх болон энэ зүйлийн 22.1-д зааснаас бусад улсад нислэгийн ажилтныг бэлтгэх сургалтын байгууллагыг иргэний нисэхийн дүрмийн дагуу шалгаж, хүлээн зөвшөөрсөн байна.

22.3. Монгол Улсад нисэхийн мэргэжлийн сургалт зохион байгуулах шалгуурыг иргэний нисэхийн дүрмээр тогтооно.

23 дугаар зүйл. Агаарын хөлгийн техник үйлчилгээ

23.1. Агаарын хөлгийн техник үйлчилгээг зохих мэргэжлийн зэрэглэл бүхий агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч гүйцэтгэнэ.

23.2. Агаарын тээвэрлэгч болон нислэгийн операторын ашиглаж буй агаарын хөлгийн шугамын техник үйлчилгээнээс бусад техник үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн Техник үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

23.3. Энэ зүйлийн 23.1-д заасныг үл харгалзан, хөөрөлтийн дээд жин нь 5700 кг-с доош жинтэй агаарын хөлгийн өдөр тутмын нислэгт бэлтгэх, нислэгийн дараах техник үйлчилгээг тус агаарын хөлгийн нисгэгч гүйцэтгэж болно.

23.4. Техник үйлчилгээний байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан техник үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, инженер, техникийн ажилтан болон тоног төхөөрөмжтэй байна.

24 дүгээр зүйл. Агаарын хөлгийн даргын эрх, үүрэг

24.1. Агаарын хөлгийн дарга нислэгийн үед онцгой нөхцөл үүссэн тохиолдолд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хууль болон иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргах эрхтэй.

24.2. Агаарын хөлгийн дарга нь агаарын хөлөг, багийн бусад гишүүд болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэр гаргах эрхтэй.

24.3. Агаарын хөлгийн дарга нь энэ хуулийн 24.1-д заасан онцгой нөхцөлийн үед иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргасан бол энэ тухай агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

24.4. Агаарын хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан зорчигчийн үйлдлийг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, тийм арга хэмжээ авахыг багийн бусад гишүүдээс шаардах эрхтэй.

24.5. Агаарын хөлгийн дарга гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байх үедээ албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

24.6. Эмнэлэгийн түргэн тусламжийн нислэг үйлдэж байгаа нисгэгч хүний амь аврах зорилгоор дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргасан бол дүрэм зөрчсөн хариуцлагаас чөлөөлөгдөнө

25 дугаар зүйл. Хувийн нислэг болон нисэх клубын нислэгийн зардал хуваах

25.1. Хувийн хэрэгцээнд үйлдэгдэх нислэгийн шууд зардлыг зорчигчтой хуваан гаргуулж болох ба агаарын хөлгийн нисгэгч, эсхүл эзэмшигч уг зардлын 50-ээс доошгүй хувийг хариуцна.

25.2. Нисэх клубын үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн хувьд танилцах болон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтны сургалтын нислэгийн шууд зардлыг клубын гишүүн, клубын үйл ажиллагаатай танилцах хүсэлтэй этгээдээс гаргуулж болно. Нисэх клуб нь тус клубын гишүүн бус этгээдэд, эсхүл хэт хөнгөн бус агаарын хөлгөөр нислэгийн сургалтын үйлчилгээ үзүүлэх бол иргэний нисэхийн дүрмийн дагуу сургалтын байгууллагын гэрчилгээ авсан байна.

26 дугаар зүйл. Гэрчилгээний шаардлагад нийцэх

26.1. Агаарын хөлөг болон байгууллага нь эзэмшиж буй гэрчилгээний шаардлагад нийцсэн байхыг дараах этгээд хариуцна:

26.1.1. хувийн агаарын хөлгийн хувьд тухайн агаарын хөлгийн эзэмшигч, нисгэгч;

26.1.2. хуулийн этгээдийн эзэмшлийн агаарын хөлгийн хувьд тухайн агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд.

26.2. Агаарын хөлгийн эзэмшигч, агаарын тээвэрлэгч болон нислэгийн оператор нь гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалд хамрагдсан байна.

26.3. Нисгэгч, агаарын тээвэрлэгч, нислэгийн оператор, нисэх клубт иргэний нисэхийн дүрмийн биелэлтэд сөргөөр нөлөөлж болох зүй бус шаардлага тавих, дарамт шахалт үзүүлэх болон бусад үйлдэл, эс үйлдлээр нөлөөлсөн бол үүссэн нөхцөл байдлын хариуцлагыг зүй бусаар нөлөөлсөн этгээд хариуцна.

26.4. Энэ зүйл нь агаарын тээвэрлэгчийг энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан тээвэрлэгчийн хариуцлагын нөхөн төлбөрийн үүргээс чөлөөлөхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

27 дугаар зүйл. Эдийн засгийн зохицуулалт

27.1. Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ. Үүнд:

27.1.1. агаарын тээвэрт эдийн засгийн үр ашигтай орчин бүрдүүлэх;

27.1.2. агаарын тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

27.1.3. агаарын тээвэрлэгч нислэгийн аюулгүй байдалд зарцуулах санхүүгийн боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх;

27.1.4. өрсөлдөөнд шударга бусаар оролцохыг хязгаарлах, бизнесийн орчинд зүй ёсны болон үүсмэл монополийн дарамт үүсэхээс сэргийлэх;

27.1.5. агаарын тээвэрт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

28 дугаар зүйл. Эдийн засгийн зохицуулалтын дүрэм

28.1. Эдийн засгийн зохицуулалтын дүрэм дараах асуудлыг хамран зохицуулна:

28.1.1. Олон улсын хуваарьт нислэгийн агаарын тээвэрлэгчид шугамын эрх олгох;

28.1.2. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох;

28.1.3. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага;

28.1.4. Агаарын хөлгийн түрээсийн бүртгэл, зохицуулалт;

28.1.5. Тээвэрлэлтийн гэрээ;

- 28.1.6. Тээвэрлэлтийн үнэ, тариф;
- 28.1.7. Хөнгөлөлтэй үнээр тээвэрлэх;
- 28.1.8. Шуудан тээвэрлэх;
- 28.1.9. Багтаамжаас давуулж борлуулах;
- 28.1.10. Зорчигчийн бүртгэл;
- 28.1.11. Нийгмийн зайлшгүй үйлчилгээний нислэгт дэмжлэг үзүүлэхэд тавих шалгуур;
- 28.1.12. Хууль тогтоомжийн дагуу дайчлагдсан агаарын тээвэрлэгч, нислэгийн оператор, агаарын хөлгийн өмчлөгчид олгох нөхөн олговор;
- 28.1.13. Агаарын тээвэрт хөгжлийн бэрхшээлийн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглох;
- 28.1.14. Агаарын навигацийн зүй ёсны монополь үйлчилгээний хураамж;
- 28.1.15. Төрийн өмчит нисэх буудлуудын үйлчилгээний хураамж;
- 28.1.16. Статистикийн мэдээлэл;
- 28.1.17. Зорчигч, ачаа илгээгч, хүлээн авагч болон олон нийтийн эрх ашигт нөлөөлж болох ашгийн төлөө тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудал.

28.2. Нийтийн эрх ашиг хохирохгүй гэж үзвэл Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эдийн засгийн зохицуулалтын дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно. Эдийн засгийн дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх зөвшөөрөл нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад этгээдэд нэгэн адил үйлчлэх бөгөөд аль нэг этгээдэд тусгайлсан хөнгөлөлт, давуу байдал олгохгүй.

29 дүгээр зүйл. Олон улсын агаарын тээвэрлэлтийн зөвшөөрөл

29.1. Агаарын тээвэрлэгчид, зорчигч тээврийн агаарын хөлгөөр олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх агаарын тээвэрлэлтийн зөвшөөрлийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

29.2 Ачаа тээврийн дагнасан нислэгийн болон орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд агаарын тээвэрлэлтийн зөвшөөрөл шаардахгүй.

29.3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд энэ хуулийн 29.1-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох хүсэлтийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргаж болно. Энэ хүсэлт нь олон улсын агаарын тээврийн шугамд шинэ тээвэрлэгч нэвтрэх эрхийг хязгаарлах хүсэлт байж болохгүй.

29.4. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ зүйлийн 29.1-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг үндэслэлгүйгээр түдгэлзүүлж, эсхүл хүчингүй болгож хөрөнгө оруулагчийг эрсдэлд оруулахгүй байх үүрэгтэй.

29.4. Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

30 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага

30.1. Агаарын тээвэрлэгч нь зорчигч, агаарын ачаа илгээгч буюу агаарын ачаа хүлээн авагчийн өмнө аюулгүй, сааталгүй тээвэрлэлтийн хариуцлага хүлээнэ.

30.2. Олон улсын агаарын тээвэрлэлтэд оролцож байгаа тээвэрлэгчийн хариуцлагын хязгаарыг Монгол Улс болон тээвэрлэлт үйлдэх гадаад улсын хамтдаа элсэн орсон олон улсын гэрээний горимоор зохицуулна.

30.3. Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд тээвэрлэгчийн хариуцлагын хязгаар дараах хэмжээтэй байна:

- 30.3.1. нислэгийн үед гарсан осол болон нислэгийн үед тохиолдсон гэнэтийн үйл явдлын улмаас зорчигчид учирсан биеийн гэмтэл, амь насны хохиролд нэг зуун сая (100,000,000.00) төгрөг;

- 30.3.2. нислэгийн үед тээш алдагдсан, гэмтсэн тохиолдолд тээвэрлүүлэхээр мэдүүлсэн ачаа, тээшний килограмм тутамд арван мянган (10,000.00) төгрөг, урьдчилан мэдүүлээгүй бол бүхэлд нь нэг зуун мянган (100,000.00) төгрөг;
- 30.3.3. ачаа, тээшийг үнэ тогтоож мэдүүлсэн бол нэрлэсэн үнийн дүнгээр. Энэ тохиолдолд тээвэрлэгч нэмэлт төлбөр авах эрхтэй.

30.4. Агаарын хөлгийн ослын улмаас зорчигч нас барсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд агаарын тээвэрлэгч энэ хуулийн 30.3-д заасны дагуу олгох бөгөөд 30.3.1-д заасан хариуцлагын хязгаарын 15 хувиас багагүй хэмжээний нөхөн олговрыг тухайн ослын хохирогчийг нас барсныг таньж тогтоосноос хойш 15 хоногийн дотор үл маргах журмаар урьдчилан төлөх үүрэгтэй.

30.5. Тээвэрлэгч нь агаарын хөлгөөр зорчигчийн амь нас, эрүүл мэнд болон гуравдагч этгээдэд учруулсан хохирол, түүнчлэн зорчигчийн тээш, ачаа, шуудан алдагдах, дутагдах буюу гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгох зориулалттай хариуцлагын даатгалд даатгуулна.

30.6. Тээвэрлэгч нь агаарын хөлгийн багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох хохирлыг даатгуулах үүрэгтэй. Агаарын хөлгийн багийн гишүүдэд олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь зорчигчийн өмнө хүлээх хариуцлагын хэмжээнээс багагүй байна.

31 дүгээр зүйл. Агаарын тээвэр дэх өрсөлдөөн

31.1. Нийгмийн зайлшгүй үйлчилгээнд татаас олгож байгаагаас бусад тохиолдолд, дотоодын агаарын тээвэрлэлтийн үнэ тарифыг төрөөс зохицуулахгүй.

31.2. Нэг нислэгийн шугамд үйлчилж байгаа агаарын тээвэрлэгчид ижил нөхцөлтэй үйлчилгээнд ижил үнэ тогтоохыг хориглоно.

31.3. Агаарын тээврийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай сум, суурин газарт хүргэх нийгмийн зайлшгүй үйлчилгээ, Засгийн газрын бодлого, дэмжлэгээр шинээр нислэгийн шугам нээж байгаагаас бусад нислэгийн шугамд өрсөлдөөнийг хязгаарлахгүй. Шинээр нээж байгаа нислэгийн шугамын өрсөлдөөний хязгаарлалт анхны тээвэрлэлт эхэлснээс хойш 36 сараас хэтрэхгүй хугацаанд үргэлжилнэ.

31.4. Агаарын тээвэрлэгч нь өөрийн эзэмшлийн техник үйлчилгээ, сургалт, газрын үйлчилгээ, шатахуун хангалтын үйлчилгээг, уг үйлчилгээ шаардлагатай өрсөлдөгчдөө үзүүлэхээс хүндэтгэх шалтгаангүйгээр татгалзах, тус үйлчилгээг зах зээлийн үнэлгээнээс өндөр үнэлэн үйлчилж өрсөлдөгчийнхөө зардлыг нэмэгдүүлэхийг хориглоно.

31.5. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өрсөлдөгч, түүний бүтээгдхүүнийг нэр зааж харьцуулсан зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

32 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөл болон ажиллах хүч

32.1. Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн хувьцааны 51-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, эсхүл хуулийн этгээдийн өмчлөлд байна.

32.2. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өмчлөлийн эрхийн талаархи аливаа өөрчлөлтийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдэгдэх үүрэгтэй.

32.3. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна.

32.4. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн ажилтны 75-аас доошгүй хувь нь агаарын тээвэрлэгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байнгын ажилтан байна. Контрактаар ажиллах нислэгийн ажилтны ажиллах хугацаа 12 сараас хэтрэхгүй байна.

32.5. Нислэгийн аюулгүй байдал болон зорчигчийн эрх ашгийг хохироосон үйлдлийн улмаас эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд агаарын тээвэрлэгчийн удирдлагад ажиллахыг хориглоно.

33 дугаар зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох

33.1. Гадаадын агаарын тээвэрлэгч нь Монгол Улс руу агаарын тээврийн нислэг үйлдэхдээ Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс зөвшөөрөл авна.

33.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах шаардлагыг хангасан гэж үзвэл тухайн зөвшөөрлийг олгож болно:

33.2.1. хүсэлт гаргагч нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг биелүүлсэн, олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр Монгол Улстай байгуулсан гэрээнд заасан нөхцөлийн дагуу томилогдсон бөгөөд тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлага хангасан байх;

33.2.2. тухайн зөвшөөрлийг олгох нь Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахгүй байх;

33.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм, аюулгүй байдлын, эсхүл тухайн зөвшөөрлийн нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох эрхтэй.

33.4. Гадаадын агаарын тээвэрлэгч нь орон нутгийн агаарын тээвэрлэлтийн үйл ажиллагаа (каботаж) эрхлэхийг хориглоно.

34 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэлтийн гэрээний нөхцөл

34.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулах агаарын тээвэрлэлтийн гэрээний нөхцөл, үнэ тариф ил тод, хэрэглэгчид ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр борлуулагчийн цахим хуудаст байрлуулсан байна. Борлуулагч нь цахим хуудас байхгүй бол гэрээ байгуулахаас өмнө гэрээний нөхцөлийг хэрэглэгчид урьдчилан танилцуулна.

34.2. Агаарын тээвэрлэлтийн гэрээний нөхцөл нь Эдийн засгийн зохицуулалтын дүрмийн шаардлагад нийцсэн байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АГААРЫН НАВИГАЦИ

35 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ

35.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллага үзүүлнэ.

35.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь агаарын навигацийн **үйлчилгээний хураамжийн орлого** болон үйл ажиллагааны **бусад** орлогоос санхүүжнэ.

35.3. Агаарын навигацийн үйлчилгээнд ашиглах радио холбооны давтамж нь хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалагдсан байна.

35.4. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд зориулсан холбоо ашиглалтгүй болсон тохиолдолд нислэгийн аюулгүй байдлыг хангах, нислэгийн хөдөлгөөн удирдах хойшлуулшгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтийн холбооны бүх төрлийн хэрэгслээр тэргүүн ээлжинд саадгүй дамжуулна.

35.5. Агаарын хөлгийн аэродромын бүсийн ойртолт, буулт хөөрөлтийн нислэгийн хөдөлгөөнд ашиглагдах агаарын навигацийн тоног төхөөрөмж нь аэродром эзэмшигчийн өмчлөлд байж болно.

35.6. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээнд ашиглах нисэхийн, газрын гадаргуугийн, саадын болон аэродромын зургийг агуулсан нисэхийн өгөгдлийн нэгдмэл санг бүрдүүлэх үүрэгтэй.

35.7. Агаарын хөлөг нислэг үйлдэж байгаа үед тухайн агаарын хөлөгт агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж байгаа агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тоног төхөөрөмжийн ажиллагааг зориудаар зогсоохыг хориглоно.

36 дугаар зүйл. Агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл

36.1. Гадаадын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн нислэгтэй холбоотой мэдээллийг агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад урьдчилан мэдэгдэж, нислэг үйлдэх зөвшөөрөл авна.

36.2. Агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын зайд орох буюу гарахдаа агаарын навигацийн үйлчилгээний байгууллагаас агаарын хил нэвтрэх зөвшөөрөл авна.

37 дугаар зүйл. Зөрчил гаргасан агаарын хөлөг

37.1. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх болон улсын хилийг орох, гарах цэгээр нэвтрэн өнгөрөх журмыг зөрчсөн, түүнчлэн эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй улсын агаарын хил нэвтэрсэн агаарын хөлгийг зөрчил гаргасан агаарын хөлөг гэж үзнэ.

37.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь зөрчил гаргасан агаарын хөлгийн талаар Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагад мэдэгдэж, агаарын хөлгийн нисэх багт зөрчлөө нэн даруй зогсоох, эсхүл заасан газарт буух шаардлага тавина.

38 дугаар зүйл. Агаарын хөлөгт тусламж үзүүлэх

38.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

38.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллага, гамшгаас хамгаалах эрх бүхий байгууллага хамтран гүйцэтгэнэ.

38.3. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд осолдсон агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүмүүсийн амь насыг аврах, эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалах үүрэгтэй.

39 дүгээр зүйл. Аюулын дохио

39.1. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлөгт тусламж үзүүлэхэд эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аюулын дохиог ашиглана.

40 дүгээр зүйл. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа

40.1. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлгийн тухай мэдээлэл нь тэргүүн ангилалд байна.

40.2. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлгийн талаар мэдээлэл авсан холбогдох байгууллага нь эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг нэн даруй зохион байгуулна.

40.3. Аэродром ашиглагч, орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлгийн баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх бололцоотой арга хэмжээ авах үүрэгтэй.

40.4. Сураггүй алга болсон агаарын хөлгийг эрэн хайх ажиллагааг зогсоох шийдвэрийг Засгийн газар гаргана.

41 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж

41.1. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж, түүний төрөл, хэмжээг эдийн засгийн зохицуулалтын дүрмийн дагуу Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

41.2. Агаарын навигацийн зүй ёсны монополь үйлчилгээ нь ашгийн бус байна. Агаарын навигацийн үйлчилгээнд орлогын төлөвлөгөө ногдуулахыг хориглоно.

41.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт буулгүйгээр дамжин өнгөрөх нислэгт үзүүлсэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.16, 8 дугаар зүйлийн 8.3, 35 дугаар зүйлийн 35.3 болон хууль тогтоомжоор тогтоосон иргэний нисэхийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

41.4. Энэ зүйлийн 41.3-т заасан санхүүжилт нь иргэний нисэхийн хяналт зохицуулалт, үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаанд тасалдал үүсгэхгүй, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр сааталгүй олгогдох байдлаар зохион байгуулагдсан байна.

42 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хөнгөлөлт

42.1. Дараах тохиолдолд агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас чөлөөлнө:

42.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэх, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин 3300 килограммаас ихгүй бол;

42.1.2. төлбөртэй ачаалалгүйгээр үйлдэж байгаа сургалт, дадлагын нислэг;

42.1.3. түргэн тусламжийн нислэг;

42.1.4. гамшгаас хамгаалах нислэг;

42.1.5. Засгийн газар, олон улсын байгууллагын хүсэлтээр үйлдэж байгаа хүмүүнлэгийн тусламжийн нислэг;

42.1.6. агаарын навигацийн тоног төхөөрөмжийг тохируулах, шалгах нислэг

42.1.7. осолдсон агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах болон ослын хохирогчдын ар гэр, ойр дотны хүмүүсийг тээвэрлэх захиалгат нислэг.

42.1.8. эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд онцгой үүргийн нислэг

42.1.9. Батлан хамгаалах болон Хил хамгаалах байгууллагын ажил үүргийн дагуу хийгдэх нислэг.

42.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нислэгт нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхдээ хялбаршуулсан журам ашиглаж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ НИСЭХ БУУДАЛ, АЭРОДРОМ

43 дугаар зүйл. Нисэх буудал, аэродром

43.1. Суудлын багтаамж нь 30 буюу түүнээс дээш зорчигчтой, хуваарьт агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг аэродром нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

43.2. Нисэх буудал, аэродромын үйлчилгээ эрхлэгч нь олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагын дагуу, тухайн аэродромыг үйл ажиллагаандаа тохирсон төхөөрөмжөөр тоноглож, нислэгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

43.3. Нутгийн захиргааны байгууллага нь Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналаар гурван мянгаас дээш байнгын оршин суугчтай суурин газарт аэродром, ерөнхий зориулалтын нисэхийн зурвас, талбай байгуулах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авна.

43.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нислэгийн аюулгүй байдлын шаардлагын үүднээс харьяалах хот, аймаг, сумын Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно.

43.5. Аэродром орчмын дэвсгэр газарт нисэхийн зориулалттай тэмдэг, гэрэл дохиололтой ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

43.6. Аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн буух, хөөрөх чиглэлийн дагуу иргэний нисэхийн дүрэмд зөвшөөрснөөс өндөр байгууламж барих, шувуу цугларах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

44 дүгээр зүйл. Нисэх буудал, аэродромын өмчлөл

44.1. Олон улсын нислэгт үйлчилдэг, эсхүл улсын нисэхтэй хамтран ашигладаг нисэх буудал, аэродром төрийн өмчлөлд байна.

44.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан хатуу хучилттай хөөрөх буух зурвас бүхий аэродромын зориулалтыг өөрчлөх, татан буулгахыг хориглоно. Хэрэв уг өөрчилж, татан буулгаж буй аэродром хувийн эсхүл орон нутгийн өмчид байгаа бол түүнийг төрийн өмчид шилжүүлэн авч болно.

44.3. Нисэх буудлыг нийтийн хэрэглээнд ашиглах зөвшөөрлийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. Энэ зөвшөөрлийг эзэмшигч нисэх буудал нь иргэний агаарын хөлөгт ялгаваргүй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

45 дугаар зүйл. Нисэх буудлын үйлчилгээний хураамж

45.1. Агаарын хөлөг, төлбөртэй зорчигч нь нисэх буудлаар үйлчлүүлэхэд нисэх буудлын үйлчилгээний хураамж төлнө.

45.2. Нисэх буудлын үйлчилгээний хураамжийн төрөл, хураамж тогтоох аргачлалыг эдийн засгийн зохицуулалтын дүрмийн дагуу тогтооно.

46 дугаар зүйл. Аэродромын үйл ажиллагааг зогсоохыг хориглох

46.1. Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд нийтэд үйлчлэхээр бэлэн байдлыг зарласан нисэх буудал, аэродром нь нислэгийн аюулгүй байдлыг хангуулах бодит шаардлагаас бусад тохиолдолд агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйл ажиллагаагаа зогсоохыг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

47 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ

47.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага үзүүлнэ.

47.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

47.3 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулах эрхтэй.

48 дугаар зүйл. Аюулгүйн үзлэг

48.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь олон улсын нислэг үйлдэх агаарын хөлөгт нэвтрэн орох аливаа этгээд болон тээвэрлэх ачаа, тээш, шууданд галт зэвсэг, тэсрэх бодис болон агаараар тээвэрлэхийг хориглосон бусад эд зүйлсийг илрүүлэх зорилгоор аюулгүйн үзлэг хийнэ.

48.2. Энэ хуулийн дагуу гүйцэтгэж байгаа аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглоно.

49 дүгээр зүйл. Нисэх буудал, агаарын навигацийн байгууламжийн хамгаалалт

49.1. Нисэх буудал болон агаарын навигацийн байгууламж нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын хамгаалалтад байж болно.

49.2. Энэ хуулийн 49.1-д заасан нисэхийн аюулгүйн үзлэг, хамгаалалтын үйлчилгээ шаардлагатай нисэх буудал болон хамгаалалтын үйлчилгээ шаардлагатай агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга батална.

50 дугаар зүйл. Агаарын хөлгийн нисэх багийн бүхээгийн халдашгүй байдал

50.1. Нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хориглоно.

50.2. Зорчигч тээврийн нислэгийн үед тийрэлтэт агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт нэг нисгэгч ганцаар үлдэхийг хориглоно.

51 дүгээр зүйл. Хэв журам зөрчсөн зорчигч

51.1. Багийн гишүүн нь нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авч болно. Энэ арга хэмжээ нь аюул учруулагч этгээдийн үүсгэж байгаа заналхийлэл, аюулын түвшинтэй дүйцэхүйц байх бөгөөд нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байна.

51.2. Энэ хуулийн 51.1-д заасан хэв журам зөрчсөн зорчигчийн үйлдлийг аюулгүй болгох арга хэмжээний журмыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

51.3. Агаарын тээвэрлэгч нь нислэгийн үеэр агаарын хөлгийн бүхээгт хэв журам зөрчсөн, зүй бус үйлдэл гарган нислэгийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан зорчигчийг дахин тээвэрлэхээс татгалзах, жагсаалтад бүртгэх, хязгаарлалт тогтоож болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ИНЦИДЕНТИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

52 дугаар зүйл. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба

52.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, ноцтой инцидент, шаардлагатай бол инцидентийг шинжлэн шалгах ажиллагааг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.

52.2. Агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах ажиллагааны үндсэн зорилго нь ослоос сэргийлэхэд чиглэгдэх бөгөөд гэм буруутныг тогтоох, хариуцлага хүлээлгэх зорилгогүй байна.

52.3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын **дэргэд** байх бөгөөд шинжлэн шалгах үйл ажиллагаа, ослын дүгнэлт нь хараат бус, бие даасан байна.

52.4. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь энэ хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагааг явуулахад хүрэлцэх хэмжээний төсөвтэй байна. Төсвийг агаарын навигацийн **үйлчилгээний** хураамжийн орлогоос санхүүжүүлнэ.

52.5. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой инцидентид өртсөн тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу оролцох бөгөөд Монгол Улсын нэрийн өмнөөс зөвхөн Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцоно.

52.6. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанаас бусад төрийн байгууллага Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын зорилгоор шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхгүй.

52.7. Энэ хуулийн 52.6 дахь заалт нь хууль хяналтын болон бусад байгууллага агаарын хөлгийн осол, инцидентийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шалгах ажиллагаа гүйцэтгэхийг хориглохгүй.

52.8. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь осол, инциденттэй холбоотой мэдээллийг цуглуулах, бүртгэх, ангилах, дүн шинжилгээ хийх бөгөөд осол, инцидентийн шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоож, шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргана.

52.9. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь шаардлагатай гэж үзвэл шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд, мөн шинжлэн шалгах ажиллагааны тайланг үндэслэн аюулгүй байдлын зөвлөмж гаргана.

52.10. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтныг осол, инциденттэй холбоотойгоор хэрэг мөрдөн байцаах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр дуудахыг хориглоно.

52.11. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах баг нь ослын газарт ажиллахад шаардагдах хамгаалах хувцас хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмж, холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

53 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах

53.1. Агаарын хөлгийн эзэмшигч, ашиглагч, хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан нь осол, инцидентийн мэдээллийг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх үүрэгтэй.

53.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба осол, инцидентийн мэдээллийг хүлээн авмагц шаардлагатай шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлэх үүрэгтэй.

53.3. Осол, инцидентэд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой нотлох баримтыг уг нотлох баримтын эзэмшигч болон холбогдох бусад этгээд тухайн шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл буюу шинжлэн шалгах албанаас өөр зааварчилгаа өгөх хүртэл хадгалж хамгаалах үүрэгтэй. Энэ заалт хүний амь насыг аврах хойшлуулшгүй арга хэмжээ авах ажиллагаанд хамаарахгүй.

53.4. Агаарын хөлгийн осол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гарсан тохиолдолд иргэн, гамшгаас хамгаалах, цагдаа, хил хамгаалах болон нутгийн захиргааны байгууллага, батлан

хамгаалахын анги салбарууд Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны үйл ажиллагаанд шаардлагатай туслалцааг даруй үзүүлэх үүрэгтэй.

53.5. Агаарын хөлгийн ослын улмаас хүний амь үрэгдсэн тохиолдолд тагнуул, цагдаагийн байгууллага болон Агаарын хөлгийн ослыг шинжлэх шалгах алба дараах байдлаар хамтран ажиллана. Үүнд:

- 53.5.1. Осол нь хүний санаатай үйлдлээс шалтгаалсан эсэхийг холбогдох хууль сахиулах байгууллага мөрдөн шалгах;
- 53.5.2. Осол нь хүний санаатай бус үйлдэл, бусад хүчин зүйлээс шалтгаалсан эсэхийг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба шинжлэн шалгах;
- 53.5.3. Энэ зүйлийн 53.5.1, 53.5.2-т заасан мөрдөн шалгах болон шинжлэн шалгах үйл ажиллагаа зэрэгцэн явагдах бөгөөд илэрсэн нотлох баримтыг хамтран ашиглах;
- 53.5.4. Осол нь хүний санаатай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдвол ослыг шалгах ажиллагааг холбогдох хуулийн байгууллага үргэлжлүүлэн мөрдөн шалгах.

54 дүгээр зүйл. Ерөнхий шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх

54.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн-шалгагч удирдах бөгөөд Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнана.

54.2. Ерөнхий шинжлэн-шалгагч нь агаарын тээврийн нисгэгч, эсхүл агаарын хөлгийн инженер мэргэжилтэй байна;

54.3. Ерөнхий шинжлэн-шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 54.3.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтан, шинжлэн-шалгагчийг томилох;
- 54.3.2. агаарын хөлгийн осол, инцидентийг ослын газар дээр шинжлэн шалгах багийг томилох;
- 54.3.3. агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах багийн ажиллагаанд дэмжлэг тусламж үзүүлэх, бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 54.3.4. шинжлэн шалгах ажиллагааны явцыг хянах, шаардлагатай урьдчилсан зөвлөмжийг гаргах, эцсийн тайланг батлах;
- 54.3.5. ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 54.3.6. ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;
- 54.3.7. Монгол Улсад ашиглагдаж байгаатай ижил маягийн агаарын хөлөгт гадаад улсад гарсан осол, ноцтой инцидентийн мэдээлэгдсэн тайланд үндэслэж аюулгүй байдлын зөвлөмж гаргах;
- 54.3.8. гарсан ослыг шинжлэн шалгах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 54.3.9. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагаанд зориулан захиран зарцуулах;
- 54.3.10. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албыг төлөөлж олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах.

55 дугаар зүйл. Шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх

55.1. Шинжлэн-шалгагч нь дараах шаардлагыг хангасан байна:

55.1.1. Агаарын тээврийн нисгэгчийн зэрэглэлтэй нисгэгч, эсхүл инженер мэргэжилтэй байна. Мөн шинжлэн-шалгагчийн сургалтанд хамрагдсан, нислэгийн үйл ажиллагаа, нислэгт тэнцэх чадвар, нислэгийн хөдөлгөөний удирдлагын, эсхүл нисэхийн менежментийн чиглэлээр ажилласан дадлага туршлага бүхий боловсон хүчин байж болно;

55.1.2. нисэхийн салбарт 55.1.1-д заасан чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

55.2. Шинжлэн-шалгагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.2.1. албан үүргээ гүйцэтгэхдээ осол, инцидентэд холбоотой нотлох баримт, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх;

55.2.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах;

55.2.3. Ерөнхий шинжлэн-шалгагчийн олгосон бусад эрх.

56 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх

56.1. Агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах ажиллагааг явуулах багийн ахлагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.1.1. осол, инцидент болсон газарт аль ч үед саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст бүрэн хяналтаа тогтоох;

56.1.2. тухайн нислэгтэй холбоотой тоон болон соронзон бичлэгүүд, бусад нотлох баримтыг өөрийн бүрэн хяналтад авах;

56.1.3. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

56.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид илтгэх, ослын шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах;

56.1.5. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

56.1.6. шинжлэн шалгах ажиллагааны урьдчилсан тайлан гаргах;

56.1.7. хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

57 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан

57.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба, шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон холбогдох байгууллагаас санал авах зорилгоор урьдчилсан тайлангийн төслийг хүргүүлнэ.

57.2. Нууц мэдээллийг нээлттэй болгох нь шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдолтой болохыг эрх бүхий байгууллага тогтоосноос бусад тохиолдолд, шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл, нотлох баримтыг хууль, тогтоомжид зааснаас өөр зорилгоор зөвшөөрөлгүйгээр задруулах, түгээхийг хориглоно.

57.3. Агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах ажиллагааны тайланг гэм буруутныг тогтоох, хариуцлага ногдуулахтай холбоотой шүүхийн болон бусад ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

58 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж

58.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь, нислэгийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлыг арилгах, сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

58.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга, холбогдох бусад этгээд болон гадаад улсад хүргүүлнэ.

58.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн хариу мэдэгдэх үүрэгтэй.

58.4. Энэ хуулийн 58.2-т заасан Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь тухайн зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

59 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх

59.1. Шинжлэн шалгах ажиллагаа дууссаны дараа тухайн ажиллагааны үр дүнг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн тохиолдолд Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны Ерөнхий шинжлэн-шалгагч шинжлэн шалгах ажиллагааг сэргээнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

60 дугаар зүйл. Үнэмлэх, гэрчилгээ, эрх хасах шийдвэр гаргах болон уг шийдвэрт гомдол гаргах

60.1. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн үйлдэл нь Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй бол Ерөнхий байцаагч, эсхүл нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч дараах арга хэмжээг авна:

60.1.1. үнэмлэх, гэрчилгээ, эрхийг 14 хоногоос 2 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх;

60.1.2. үнэмлэх, гэрчилгээ, эрхийг цуцлах буюу хүчингүй болгох;

60.1.3. энэ хуулийн 64.1.2-т заасан арга хэмжээ авагдсан этгээдийн үнэмлэх, гэрчилгээ, эрх сэргээх өргөдөл гаргах эрхийг 1 жил хүртэлх хугацаагаар хасах.

60.2. Онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэр гаргахын өмнө тухайн гэрчилгээ, эсхүл үнэмлэх эзэмшигчид тайлбар өгөх боломж олгох үүрэгтэй.

60.3. Үнэмлэх, гэрчилгээнд нь үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулсан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүйд тооцсон шийдвэр гаргасан гэж үзвэл эзэмшигч нь дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

60.4. Энэ хуулийн 60.3-т заасан гомдлыг хүлээн авсан дээд шатны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гаргагчийн гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нягтлан үзэж, шийдвэр гаргагчийн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл цуцлаж дахин өөр шийдвэр гаргана.

60.5. Энэ хуулийн 60.4-т заасан дээд шатны шийдвэртэй гомдол гаргасан үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ эзэмшигч санал нийлэхгүй байвал шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

ГАРЫН ҮСЭГ